



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянтүмэн сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/14/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.17 № 52
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.ЧУЛУУНТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянтүмэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянтүмэн сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020035



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн Сайдан баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2181076.00</u>	<u>1252126.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2181076.00	1252126.00
351	Түүхий эд материал	0.00	0.00
354	Хангамжийн материал	2181076.00	1252126.00
35420	Аж ахуйн материал	441589.00	381599.00
35470	Бусад хангамжийн материал	1739487.00	870527.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3093797.69</u>	<u>2384999.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3093797.69	2384999.81
392	Биет хөрөнгө	3093797.69	2384999.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5449130.00	2767000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4433266.53	-1183999.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4419200.00	1310000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2341265.78	-508000.22
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5274873.69</u>	<u>3637125.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5274873.69</u>	<u>3637125.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5274873.69	3637125.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2667500.00	2667500.00
51101	Өмч: - төрийн	2667500.00	2667500.00
512	Хуримтлагдсан үр дүн	2607373.69	969625.81
51210	Өмнөх үеийн үр дүн	2607373.69	2607373.69
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-1637747.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5274873.69</u>	<u>3637125.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>50207900.00</u>	<u>270986800.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1310000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1310000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1310000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	1310000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50207900.00	269676800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1000000.00	201000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	201000000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49207900.00	68676800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49207900.00	68676800.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	52202564.82	270679953.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52202564.82	270679953.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51681153.82	65950347.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40375493.00	48935610.62
210101	Үндсэн цалин	33004776.00	26829545.60
210102	Нэмэгдэл	0.00	11697720.02
210104	Урамшуулал	7370717.00	10408345.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4111300.00	4498223.00
210201	Тэтгэврийн даатгал	2880800.00	2955411.00
210202	Тэтгэмжийн даатгал	307600.00	385704.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	246100.00	308562.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61500.00	77142.00
210205	Эрүүл мэндийн даатгал	615300.00	771404.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2204011.00	2985790.00
210401	Бичиг хэрэг	316615.00	579400.00
210402	Тээвэр, шатахуун	1336000.00	1730000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	71380.00	6000.00
210404	Ном, хэвлэл	272000.00	294000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	208016.00	284400.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	91990.00
2105	Нормативт зардал	132000.00	33000.00
210502	Хоол, хүнс	0.00	33000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	50000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100000.00	50000.00
210604	Урсгал засвар	400000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	654200.00	0.00
210702	Дотоод албан томилолт	654200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	344800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	330000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	14800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3704149.82	9102923.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1436486.00	8026620.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250000.00	12100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2017663.82	1064203.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	521411.00	204729606.38
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420000.00	200250000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	200000000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420000.00	250000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101411.00	4479606.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101411.00	4479606.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1994664.82	306846.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1944593.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	1944593.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-1944593.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1994664.82	-1637747.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	50207900.00	269676800.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50207900.00	269676800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1000000.00	201000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	201000000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49207900.00	68676800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49207900.00	68676800.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	50207900.00	267976800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50207900.00	267976800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49686489.00	63247193.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40375493.00	48935610.62
210101	Үндсэн цалин	33004776.00	26829545.60
210102	Нэмэгдэл	0.00	11697720.02
210104	Урамшуулал	7370717.00	10408345.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4111300.00	4498223.00
210201	Тэтгэврийн даатгал	2880800.00	2955411.00
210202	Тэтгэмжийн даатгал	307600.00	385704.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	246100.00	308562.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61500.00	77142.00
210205	Эрүүл мэндийн даатгал	615300.00	771404.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2227010.00	2926800.00
210401	Бичиг хэрэг	316615.00	579400.00
210402	Тээвэр, шатахуун	1336000.00	1730000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	71380.00	6000.00
210404	Ном, хэвлэл	272000.00	294000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	231015.00	317400.00
2105	Нормативт зардал	132000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	50000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100000.00	50000.00

210604	Урсгал засвар	400000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	654200.00	0.00
210702	Дотоод албан томилолт	654200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	344800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	330000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	14800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1686486.00	6491760.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1436486.00	6291760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250000.00	200000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	521411.00	204729606.38
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420000.00	200250000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	200000000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420000.00	250000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101411.00	4479606.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101411.00	4479606.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	1700000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	1700000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1700000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1700000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1700000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-1700000.00
14	Бусад эх үүсвэр	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.00	0.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,667,500.00	0.00	2,607,373.69	0.00	5,274,873.69

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,667,500.00	0.00	2,607,373.69	0.00	5,274,873.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,667,500.00	0.00	2,607,373.69	0.00	5,274,873.69
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,667,500.00	0.00	2,607,373.69	0.00	5,274,873.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,667,500.00	0.00	2,607,373.69	0.00	5,274,873.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,637,747.88	0.00	-1,637,747.88
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,667,500.00	0.00	969,625.81	0.00	3,637,125.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49207900.00	49106489.00	68676800.00	64197193.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49207900.00	49106489.00	68676800.00	64197193.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48787900.00	48686489.00	68376800.00	63947193.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40391200.00	40375493.00	49742100.00	48612542.62
210101	Үндсэн цалин	33011200.00	33004776.00	26400000.00	25761017.60
210102	Нэмэгдэл	0.00	0.00	12600000.00	12443180.02
210104	Урамшуулал	7380000.00	7370717.00	10742100.00	10408345.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4111300.00	4111300.00	5670000.00	4821291.00
210201	Тэтгэврийн даатгал	2880800.00	2880800.00	3988300.00	3278479.00
210202	Тэтгэмжийн даатгал	307600.00	307600.00	419900.00	385704.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	246100.00	246100.00	336800.00	308562.00

210204	Ажилгүйдлийн даатгал	61500.00	61500.00	84100.00	77142.00
210205	Эрүүл мэндийн даатгал	615300.00	615300.00	840900.00	771404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2134700.00	2109010.00	2480000.00	2496800.00
210401	Бичиг хэрэг	305400.00	316615.00	400000.00	379400.00
210402	Тээвэр, шатахуун	1278000.00	1278000.00	1500000.00	1500000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8500.00	11380.00	30000.00	6000.00
210404	Ном, хэвлэл	300000.00	272000.00	300000.00	294000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242800.00	231015.00	250000.00	317400.00
2105	Нормативт зардал	0.00	0.00	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	500000.00	2650000.00	1750000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100000.00	100000.00	1750000.00	1750000.00
210602	Тавилга	0.00	0.00	600000.00	0.00
210604	Урсгал засвар	400000.00	400000.00	300000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	654200.00	654200.00	1007100.00	0.00
210702	Дотоод албан томилолт	654200.00	654200.00	1007100.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60000.00	0.00	527600.00	344800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60000.00	0.00	330000.00	330000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00	180000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00	17600.00	14800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	936500.00	936486.00	6300000.00	5921760.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	936500.00	936486.00	6300000.00	5921760.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420000.00	420000.00	300000.00	250000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420000.00	420000.00	300000.00	250000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420000.0	420000.0	300000.00	250000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49207900.00	49207900.00	70977500.00	68676800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49207900.00	49207900.00	70977500.00	68676800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	49207900.00	49207900.00	70977500.00	68676800.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2.00	2.00	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		201,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		201,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		430,000.00
210401	Бичиг хэрэг		200,000.00
210402	Тээвэр, шатахуун		230,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		570,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		570,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		200,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		200,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		200,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		201,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		201,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		201,000,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Чулуунтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 03-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянтүмэн сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянтүмэн сумын ИТХ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн санхүү хяналт дотоод аудитын албанаас 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Баянтүмэн сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 44,000.8 мянган төгрөгөөс тооцон 880.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,452.5 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянтүмэн сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,637.8 мянган төгрөгөөр буюу 31,0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал болон үндсэн хөрөнгийн дансны бууралттай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	2,181.1	1,252.1	-929.0
Үндсэн хөрөнгө	9,868.3	4,077.0	-5,791.3
Элэгдэл	-6,774.5	-1,692.0	5,082.5
Нийт хөрөнгө	5,274.9	3,637.1	-1,637.8
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,274.9	3,637.1	-1,637.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,274.9	3,637.1	-1,637.8

Авлага дансанд өөрчлөлт ороогүй. Авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,252.1 мянган төгрөг болж 929,0 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материал 869.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 60,0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,077.0 мянган төгрөг болж 5,791.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Баянтүмэн сумын ИТХ-н 2020.05.27 №17 тогтоолоор 6,092.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж ЗДТГ-т шилжүүлж, 1,999.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж, тус тогтоолоор 879.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хандиваар авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй. Өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,637.1 мянган төгрөг болж 1,637.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Баянтүмэн сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 220,778.9 мянган төгрөгөөр буюу 5,3 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь хэлмэгсдийн ар гэрт олгох тэтгэмжийн санхүүжилт 200,0 сая төгрөгөөр, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нэмнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 218,477.4 мянган төгрөгөөр буюу 5,1 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт хэлмэгсдийн ар гэрт олгосон 200,0 сая төгрөгийн тэтгэмж, цалин хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь хэлмэгсдийн ар гэрт олгосон тэтгэмж болон Засгийн газраас цалин хөлс нэмснээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 70,977.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 70,977.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагч нь хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан ч ИТХ-ын 2020 оны 12 сарын 4-ний хурлаар төсөвт тодотгол хийн 68,676.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цар тахалтай холбоотой зарим зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /код-70105/ хөтөлбөрийн 1 /код-80101/ арга хэмжээг санхүүжүүлэхээр 68,676.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 68,676.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 64,197.2 мянган төгрөгийг зарцуулж 4,479.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 64,197.2 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байгаа нь Цалин хөлс, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 1,978.3 мянган төгрөгөөр, эд хогшил материалын зардлыг 900.0 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,007.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 163.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний

төлбөрийг 2.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 378.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 50.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үр дүнгийн урамшууллыг олгоогүй, цар тахалтай холбоотой томилолт зочны зардал хэмнэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны орлогыг дээд шатны төсвийн захирагчаас олгосон 1,000.0 мянган төгрөгийн орлогоор бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардал буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 1,000.0 мянган зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого, эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 3 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,941.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,941.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал гараагүй тул залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 70,941.2 мянган төгрөгийн, худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй 3,941,2 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Баянтүмэн сумын ИТХ нь 70,977.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд хоцроон байршуулсан нь Шилэн дансны 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил



бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор", 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.7 дах "байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд хийсэн 3,941.2 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.5 дахь хэсэгт "... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5 дахь заалт Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.


Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Худалдан авалтын татварын е-баримтыг харилцагч байгууллагаас заавал гаргуулж авч баримтад бүрэн хавсаргасныг шалгана.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны
---	---------------------------	------------	---------------------------------------	---



				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд хийсэн 3,941.2 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй	3,941.2		Дарга Нягтлан бодогч	Б.Чулуунтуяа А.Нарантунгалаг
2	Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг тулган шалгахад нийт 137 мэдээ байршуулах ёстойгоос тухайн жилийн төсөв, хөрөнгө оруулалт, орон тооны мэдээлэл зэрэг 3 мэдээллийг хоцроон мэдээлсэн байна	70,977.5		Дарга	Б.Чулуунтуяа
ДҮН		74,918.7			